



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/557

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3 дахь заалтууд, Эрүүл мэндийн тухай Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ховд аймагт Өрхийн эрүүл мэндийн байгууллага үүсч хөгжсөний 20 жилийн ойн хүрээнд харьяа өрхийн иргэдэд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулахад шаардагдах нэг удаагийн урвалж оношлуурын зардалд 900 000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2.Зардалд шаардагдах 900 000 төгрөг /есөн зуун мянган/-ийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 5.12 дахь заалтын "Эрүүл мэндийн эрсдлийг бууруулах" төсөл, хөтөлбөрийн зардлаас тооцож олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ч.Уранчимэг/-д хариуцуулсугай.

ЗАСАГ ДАРГА


Б.ДҮГЭРЖАВ



D/Zax-A/557-Da

00 00772

Аймгийн Засаг даргын 2019 оны
09 дүгээр сарын 06-ны өдрийн
А/557 дугаар захирамжийн хавсралт



ХАРЪЯА ӨРХИЙН ИРГЭДЭД ЭРҮҮЛ МЭНДИЙН
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД
ШААРДАГДАХ НЭГ УДААГИЙН УРВАЛЖ ОНОШЛУУРЫН ТООЦОО

№	Өрхийн эмнэлгийн нэр	Зардлын утга	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт үнэ /мян төг/
1	Баатархайрхан өрх	Нэг удаагийн урвалж	100	1500	150 000
2	Буянт өрх	Нэг удаагийн урвалж	100	1500	150 000
3	Булган өрх	Нэг удаагийн урвалж	100	1500	150 000
4	Бугат өрх	Нэг удаагийн урвалж	100	1500	150 000
5	Рашаант өрх	Нэг удаагийн урвалж	100	1500	150 000
6	Жаргалан өрх	Нэг удаагийн урвалж	100	1500	150 000
НИЙТ ДҮН			600 ш		900 000